



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/198

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын тушаалаар хүн амын эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгийн зохион байгуулах арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд дурангийн оношлогоонд хамрагдах иргэдийн тоо олон, мэргэшсэн эмчийн тоо бага, орон нутагт үзлэг хийх дуран хүрэлцэхгүй байгаа тул Улаанбаатар хот болон орон нутгийн хувийн эмнэлгүүдтэй гэрээ хийж 23 сумдын 2300 иргэдийг дурангийн оношлогоонд хамруулахад шаардлагатай үйл ажиллагааны зардалд 39,100,000 төгрөг, 23 суманд хүрч үйлчлэх шатахууны зардалд 3,927,600 төгрөг, нийт 43,027,600 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 43,027,600 (Дөчин гурван сая хорин долоон мянга зургаан зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Сумдад ажиллах хамтарсан багийн эрт илрүүлэг үзлэгийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган мэдээ тайланг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Ч.Ганбаатар), Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН